



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалт дахин зохион
байгуулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт"-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.



ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
хуралдааны 2025 оны 9 сарын 18-ны
өдрийн 10-гоот тогтоолын хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ГОВЬСҮМБЭР, ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АРИЛЖААНЫ
ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

ДУГААР :АрТВ-Орон нутаг-2025-2

Огноо: 2025 он

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн төрөл ангилал, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрхзүйн үндсийг тодорхойлж, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, радио, телевизийн хөтөлбөрт хууль, журамд заасан үзүүлэлтээр шаардлага тавих хууль эрхзүй, зохицуулалтын орчин бүрдсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9¹-д заасан эрх, үүргийн хүрээнд тухайн жилд олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тогтоодог бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1² дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5³ дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6⁴ дахь заасны дагуу арилжааны радио, телевиз, өргөн нэвтрүүлгийн радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ, радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгож байна.

Иймд тус хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоол⁵-ыг үндэслэн Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг баримтлан зохион байгуулахаар орон “Говьсүмбэр, дундговь аймгийн нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын баримт бичиг”-ийг батлав.

¹ Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;

² Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.15, 1.23, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18 дахь заалт, 5 дахь хэсгийн 5.1 дэх заалт, 8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх заалт, 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11 дэх заалт, 11 дэх хэсгийн 11.1, 11.9, 11.12 дахь заалт, 12 дахь хэсгийн 12.1, 12.2, 12.14 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

³ энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;

⁴ Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.

⁵ Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГОВЬСҮМБЭР, ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Зарласан огноо: 2025 оны 09 сарын 22-ны өдөр

Нээлттэй сонгон шалгаруулалтын дугаар: **АрТВ-Орон нутаг-2025-2**

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115, 09 дүгээр сарын 18-ны өдрийн 207 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах хамрах хүрээнд олгохоор нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байна. Үүнд:

№	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хамрах хүрээ	Тусгай зөвшөөрлийн олгох хугацаа	Олгох тусгай зөвшөөрлийн тоо
1	Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	Говьсүмбэр	5 жил	1
2		Дундговь	5 жил	1

Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох саналыг хүлээн авах эцсийн хугацаа:

[2025 оны 10 дугаар сарын 23 -ны өдрийн 11:00 цаг]

Нээлттэй сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналыг нээх хугацаа:

[2025 оны 10 дугаар сарын 23 -ны өдрийн 11:30 цаг]

Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн этгээд нь Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт “**Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг**”-ийг тус хорооны www.crc.gov.mn сайтаас татах болон хариуцсан мэргэжилтэнд хандан авах боломжтой.

Сонирхсон этгээд сонгон шалгаруулалттай холбоотой бусад мэдээллийг албан бичгээр Зохицуулах хорооны сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт хаяглан ирүүлнэ үү.

Шуудангийн хаяг: **Харилцаа Холбооны Зохицуулах Хороо**

Метро бизнес төв А-блок 5 давхар, Сүхбаатар дүүрэг,

Д.Сүхбаатарын гудамж -13, Улаанбаатар хот

14201-0033, Монгол Улс.

Утас: +976-11-304258, 1800-1858

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1 Сонгон шалгаруулалтын цар хүрээ

- 2.1.1. Энэхүү нээлттэй сонгон шалгаруулалтыг *Говьсүмбэр, Дундговь* аймгийн нутаг дэвсгэрт тус тус нэг *“Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх”* тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулахаар зохион байгуулж байна.
- 2.1.2. Нээлттэй сонгон шалгаруулалтад (цаашид “сонгон шалгаруулалт” гэх) Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү баримт бичгийг баримтална.

2.2 Эрх бүхий сонгон шалгаруулалтад оролцогч

- 2.2.1. Сонгон шалгаруулалтад Монгол Улсад бүртгэлтэй, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4.3-т зааснаас бусад хуулийн этгээд оролцоно.
- 2.2.2. Сонгон шалгаруулалтад дараах хуулийн этгээдийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
- (а) Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 7.4.3-т заасан этгээдүүд;
- (б) Сонгон шалгаруулалтын төсөл, нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн;

Б. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ (СШББ)

2.3. Төслийг бүрдүүлэх

- 2.3.1. Төслийн иж бүрдлийг энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичгийн 2.7-2.11 дэх заалтын дагуу бүрдүүлэх ба төслийн иж бүрдлийг маягт №6-д бүртгэж ирүүлнэ.

2.4. Сонгон шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

- 2.4.1. Оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга, тайлбар авах шаардлагатай бол хүсэлтээ албан бичгээр Зохицуулах хорооны сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт (цаашид “Үнэлгээний ажлын хэсэг” гэх) гэж хаяглан ирүүлнэ.
- 2.4.2. Үнэлгээний ажлын хэсэг нь төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 7 (долоо)-оос доошгүй хоногийн өмнө ирүүлсэн тодруулга авах хүсэлтэд хариу өгнө.

2.5. Сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

- 2.5.1. Зохицуулах хороо нь төслийг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө СШББ-т нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 2.5.2. СШББ-т оруулсан нэмэлт, өөрчлөлт нь СШББ-ийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

- 2.5.3. Шаардлагатай тохиолдолд СШББ-т орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгах хангалттай хугацаа оролцогчдод олгох үүднээс Зохицуулах хороо нь төслийг хүлээн авах эцсийн хугацааг 1 удаа сунгаж болно.

В. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ

2.6. Төслийн ерөнхий болон үнэлгээний нөхцөл, шаардлага

- 2.6.1. Төсөл нь монгол хэл дээр байна. *(Жич: Зөвхөн техникийн холбогдолтой зарим хавсралт материалууд англи хэл дээр байж болно. Бусад хэл дээрх материалыг монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулан эх хувийг хавсаргасан байна.)*
- 2.6.2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэгт заасны дагуу энэхүү баримт бичгийн 2.7-2.11 хүртэл нөхцөлүүдийг хангах баримт, материалыг ирүүлнэ.

2.7. Төслийн ерөнхий шаардлага

- 2.7.1. Сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийн маягт №1-ийн дагуу албан бичиг ирүүлнэ;
- 2.7.2. Үнэлгээний ажлын хэсэгт Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн мэдээлэл болон Сангийн яамны цахим системийн мэдээлэлтэй танилцах зөвшөөрлийг маягт №2-ын дагуу албан бичгийн дагуу ирүүлнэ;
- 2.7.3. Хуулийн этгээдийн хүчин төгөлдөр дүрмийн хуулбар ирүүлнэ;
- 2.7.4. Иж бүрдлийн хүснэгтийг СШББ-ийн маягт №6-г бөглөж хуудасны дугаарыг үнэн зөв тэмдэглэн ирүүлнэ;
- 2.7.5. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.5-д заасныг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын багийн бүрэлдэхүүний танилцуулгыг маягт №7-ын дагуу ирүүлнэ (аль улсын иргэн болохыг бичиж, гадаадын иргэн бол паспортын хуулбар, гадаадын хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, түүний албан ёсны орчуулгын баталгаажуулсан хувь);
- 2.7.6. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2.1, 19.2.2, 19.2.3-д заасан эзэмшлийн талаарх мэдээллийг маягт №8-ын дагуу ирүүлнэ.

2.8. Телевизийн үйлчилгээ эрхлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, баталсан байх;

- 2.8.1. Телевизийн үйлчилгээ эрхлэх хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий батлагдсан 5 жилийн стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг маягт №5-ын дагуу ирүүлнэ;

2.9. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын, хүний нөөцийн, техник технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;

- 2.9.1. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хангах санхүүгийн чадавхийг нотлох баримтууд. Үүнд:

а. Оролцогчийн 2024 оны жилийн эцсийн, 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан;

б. Бусдын хөрөнгө оруулалтаар төслийг санхүүжүүлэх бол хөрөнгө оруулагчийн 2024 оны жилийн эцсийн, 2025 оны хагас жилийн санхүүгийн

тайлан, удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн гэрээ, баримт бичиг ирүүлнэ;

в. Төслийг зээлээр санхүүжүүлэх бол зээл олгох этгээдийн эрх бүхий албан тушаалтны шийдвэр, холбогдох баримт бичиг ирүүлнэ.

2.9.2. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн чадавхийг нотлох баримтууд. Үүнд:

а.Энэхүү баримт бичгийн 2.8.1-д заасан стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн баг бүрдүүлсэн тухай мэдээллийг ирүүлэхдээ маягт №3-ын дагуу ирүүлнэ;

б.Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай инженер техникийн ажилтнуудын, диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлнэ.

2.9.3. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн шаардлагыг хангасныг нотлох баримтууд /“MNS 5592-1 :2012 Телевизийн студи. Үндсэн шаардлага”, “MNS 5592-2 : 2016 Тоон телевизийн студи. Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” стандартуудыг хангасан байх/

а.Үндсэн техник, тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн танилцуулга, жагсаалтыг маягт №4-т зааснаар гаргаж ирүүлнэ;

б.Техник, тоног төхөөрөмжийн үндсэн үүрэг, зориулалт, үзүүлэлтүүдийн жагсаалт, тоног төхөөрөмжийн холболтын схем, зураглал, тайлбарын хамт ирүүлнэ;

в. Техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээ ирүүлнэ.

2.10. Телевизийн үйлчилгээний төлөвлөлт, хөтөлбөр нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасан тавигдах шаардлагыг хангасан байх

2.10.1 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т заасан Редакцын бодлого, дүрмийг баталж ирүүлэх ба хүүхэд хамгаалын талаар тусгасан байх;

2.10.2 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10.8.4, 23 дугаар зүйлийн 23.5-д заасан хөтөлбөрт тавигдах шаардлагыг хэрхэн хангаж ажиллах талаарх төлөвлөлт, бүтээл, нэвтрүүлгийн жагсаалт, танилцуулга, 30 хоногийн хөтөлбөр ирүүлнэ;

2.11. Өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө.

2.11.1 Төслийг хэрэгжүүлснээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд үзүүлэх нөлөө, үнэ тариф, хөтөлбөр, агуулга, чанараар өрсөлдөх зэргийг судалсан судалгааг ирүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Г. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД

3.1 Төсөл хүчинтэй байх хугацаа

- 3.1.1 Төсөл нь нээсэн өдрөөс хойш ажлын 60 [жар] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 3.1.2 Үнэлгээний ажлын хэсэг нь гамшгийн болон онцгой нөхцөл байдлын улмаас төсөл хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд бүх оролцогчдод мэдэгдэнэ.

3.2 Төсөл ирүүлэх хувь, төсөлд гарын үсэг зурах

- 3.2.1 Оролцогч нь 2.7-2.11 дүгээр зүйлд заасан төслийн иж бүрдэл болон бусад бичиг баримтын эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Оролцогч нь үүнээс гадна 1 ширхэг “ЦАХИМ ХУВЬ” бэлтгэн ирүүлнэ.
- 3.2.2 Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгон шалгаруулалтад тухайн хуулийн этгээдийг төлөөлөх бол итгэмжлэлийг эрх бүхий этгээдээс албан бичгээр авсан байна.
- 3.2.3 Сонгон шалгаруулалтад оролцогч зөвхөн нэг хувилбараар төсөл ирүүлнэ.

Д. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ ИРҮҮЛЭХ

3.3 Төслийг битүүмжлэх, бичиглэл хийх

- 3.3.1 Оролцогч нь саналын ЭХ ХУВЬ (цаасаар) болон ЦАХИМ ХУВЬ (PDF өргөтгөлтэйгөөр зөөврийн санах ой (USB flash drive эсвэл compact disc))-ийг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ЦАХИМ ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн үнэлгээний ажлын хэсэгт **урилгад заасан шуудангийн хаягаар** ирүүлнэ.
- 3.3.2 ЭХ ХУВЬ болон ЦАХИМ ХУВЬ хоорондоо зөрчилдсөн тохиолдолд ЭХ хувийг баримтална.
- 3.3.3 ЭХ ХУВИЙН хуудас тус бүрийг дугаарлаж, тамга дарж баталгаажуулна.
- 3.3.4 Дугтуйнууд дээр дараах тэмдэглэгээ, бичиглэлийг хийнэ. Үүнд:
 - а. Сонгон шалгаруулагч байгууллагын нэр, шуудангийн хаяг;
 - б. Сонгон шалгаруулалтын нэр, дугаар;
 - в. Сонгон шалгаруулалтын төслийг нээх 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 30 минутаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэсэн бичиглэл;
 - г. Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр, шуудангийн хаяг, утас.

3.4 Төсөл хүлээн авах эцсийн хугацаа

- 3.4.1 Төслийг 3.3.1 заалтын дагуу битүүмжлэн, 3.3.4 заалтын дагуу тэмдэглэгээ, бичиглэлийг хийж Зохицуулах хорооны шуудангийн хаягаар, төсөл хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минутаас хоцроолгүйгээр ирүүлнэ.
- 3.4.2 Төслийг хүлээн авахад Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн газрын цаг, давтамжийн эталон цагийн серверийн мастер цагийг баримтална.

- 3.4.3 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 2.5-ийн дагуу СШББ-т нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас төсөл хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг болон оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр үйлчилнэ.
- 3.4.4 Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэний улмаас шаардлагатай гэж үзвэл Зохицуулах хороо нь төсөл хүлээн авах эцсийн хугацааг нэг удаа сунгаж болно. Сунгасан тухай мэдэгдлийг нийт оролцогчдод албан бичгээр хүргэнэ.
- 3.5 Хугацаа хоцорсон сонгон шалгаруулалтын төсөл**
- 3.5.1 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 3.4.1-т заасан төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа төслийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

Е. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ ХҮЛЭЭЖ АВАХ, НЭЭХ

3.6 Төсөл хүлээн авах, нээх үйл ажиллагаа

- 3.6.1 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг 3.3.4 дэх заалтын дагуу сонгон шалгаруулалтад (цаашид сонгон шалгаруулалт гэх) ирүүлсэн төслийн зөвхөн гаднах хайрцгийн битүүмжлэл, бичиглэлийг шалгаж, хүлээн авна.
- 3.6.2 Оролцогчийн ирүүлсэн төсөл нь энэхүү баримт бичгийн 3.3.4 (зөвхөн гаднах дугтуйны битүүмжлэл, бичиглэл хамаарна), 3.4.1 дэх заалтад заасан шаардлагуудыг хангаагүй бол үнэлгээний ажлын хэсэг нь тухайн төслийг хүлээж авахаас татгалзаж, буцаана.
- 3.6.3 Үнэлгээний ажлын хэсэг нь төсөл хүлээж авсан тухайгаа тэмдэглэл хөтөлж, уг төслийг хүлээлгэж өгсөн сонгон шалгаруулалтад оролцогчийн төлөөлөгчдөд танилцуулан, гарын үсэг зуруулна (маягт №9).
- 3.6.4 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор хүлээн авсан төслүүдийг оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ. Нээх тодорхой хугацаа, байршлыг оролцогчдод төсөл хүлээн авах үед мэдэгдэнэ.
- 3.6.5 Сонгон шалгаруулалтын нээлтэд оролцогчийн төлөөлөгч байлцах эрхтэй ба нээлтэд оролцоогүйгээс үүсэх хариуцлагыг үнэлгээний ажлын хэсэг хүлээхгүй.
- 3.6.6 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын нээлт дээр төсөл ирүүлсэн оролцогчдын нэрийг зарлаж, тэмдэглэл үйлдэн, оролцогчдоор гарын үсэг зуруулна (маягт №10).
- 3.6.7 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг үнэлэх хүртэл хүлээн авсан төслийн материалуудыг бүрэн бүтэн хадгална.

Ё. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ

3.7 Үнэлгээний ажлын хэсэг

- 3.7.1 Үнэлгээний ажлын хэсэг нь дарга, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн 7-оос доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зохицуулах хорооны даргын тушаалаар байгуулна.

- 3.7.2 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг хүлээн авах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох хүртэл үүсэх харилцаанаас олж авсан бүхий л мэдээллийг задруулахыг хориглоно.
- 3.7.3 Үнэлгээний ажлын хэсэг нь нууцын баталгаа гаргана. (маягт №11).
- 3.7.4 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлтийг Зохицуулах хорооны хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.7.5 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг хянан үзэхээс өмнө Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар"-ыг гаргана. (маягт №12)
- 3.7.6 Хэрэв үнэлгээний ажлын хэсгийн дарга, нарийн бичиг, гишүүн нь албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй бол мэдэгдэл гаргана. Эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн бол тайлбарыг гаргаж тухайн чиг үүргийн үнэлгээний ажлын хэсэгт ажиллахаас татгалзана.

3.8 Төслийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 3.8.1 Үнэлгээний ажлын хэсэг нь эрх бүхий оролцогчийн төслийг нарийвчлан үнэлэхээс өмнө төслийн иж бүрдлийг хангасан эсэхийг СШББ-ийн маягт №6-ийн дагуу хянан үзнэ.
- 3.8.2 СШББ-ийн маягт №6-д заасан иж бүрдлийг бүрэн хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгад өөрчлөлт оруулаагүй төслийг ШААРДЛАГАД НИЙЦСЭН төсөл гэнэ.
- 3.8.3 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 3.8.2-т зааснаас бусад төслийг ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ гэж үзэж, уг төслийг нарийвчилсан үнэлгээнд оруулахаас татгалзана.
- 3.8.4 Үнэлгээний ажлын хэсэг нь зөвхөн СШББ-ийн 3.8.2-д заасан ШААРДЛАГАД НИЙЦСЭН гэж хянан үзсэн төслийг СШББ-ийн 3.9 дүгээр зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

3.9 Төслийг үнэлэх, харьцуулах

- 3.9.1 Үнэлгээний ажлын хэсэг нь зөвхөн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн төслийг дараах үзүүлэлтүүдийн дагуу үнэлнэ. Үүнд:

СШББ №	СШББ-т тодорхойлсон нөхцөл, шаардлагууд	Үнэлгээний оноо
Телевизийн үйлчилгээ эрхлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, баталсан байх (нийт оноо 15)		
2.8.1	Телевизийн үйлчилгээ эрхлэх хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий батлагдсан 5 жилийн стратеги төлөвлөгөө	10 хүртэл
2.8.2	Төлөвлөгөөнд маягт №5-ын дагуу саналыг хэрэгжүүлэх хугацааны хуваарь;	5 хүртэл
Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхи (нийт оноо 20)		
2.9.2.а	Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хангах санхүүгийн чадавхи бүрдүүлсэн байдал	20 хүртэл
Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд		

шаардлагатай хүний нөөцийн чадавхи (нийт оноо 15)		
2.9.2.a	Хүний нөөц бүрдүүлсэн байдал	10 хүртэл
2.9.2.б	Мэргэжлийн инженер техникийн ажилтнаар хангагдсан байдал	5 хүртэл
Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн шаардлагыг хангасныг нотлох баримтууд (нийт оноо 20)		
2.9.3.a	Үндсэн техник, тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн танилцуулга, жагсаалт	5 хүртэл
2.9.3.б	Техник, тоног төхөөрөмжийн үндсэн үүрэг, зориулалт, үзүүлэлтүүдийн жагсаалт, тоног төхөөрөмжийн холболтын схем, зураглал, тайлбар	10 хүртэл
2.9.3.в	Техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байдал, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй эсэх	5 хүртэл
Телевизийн хөтөлбөр төлөвлөлт, “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ыг хангасан байдал (нийт оноо 25)		
2.10.1	Редакцын бодлого, дүрэм	5 хүртэл
2.10.2	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10.8.4, 23 дугаар зүйлийн 23.5-д заасан хөтөлбөрт тавигдах шаардлагыг хэрхэн хангаж ажиллах талаарх төлөвлөлт, бүтээл, нэвтрүүлгийн жагсаалт, танилцуулга, 30 хоногийн хөтөлбөр	20 хүртэл
Өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө (нийт 5 оноо)		
2.11.1	Төслийг хэрэгжүүлснээр өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөөг судалсан байдал	5 хүртэл
	Нийт оноо	100 оноо

- 3.9.2. Үнэлгээний ажлын хэсэг нь төсөл тус бүрийг 100 хүртэл оноогоор үнэлж, авсан дундаж оноогоор эрэмбэлнэ.
- 3.9.3. Авбал зохих 100 онооны 80 ба түүнээс дээш оноог авсан бол тэнцсэнд, 80-с доош оноо авсан тохиолдолд тухайн сонгон шалгаруулалтын төслийг тэнцээгүйд тооцно.
- 3.9.4. Хэрэв оролцогчдын оноо тэнцсэн тохиолдолд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааны хуваарь, телевизийн хөтөлбөр төлөвлөлт, “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ыг хангасан байдлын оноог харгалзан үзнэ.
- 3.9.5. Үнэлгээний ажлын хэсэг нь шалгарсан оролцогчдыг авсан оноогоор нь харьцуулалт хийж, хамгийн өндөр онооноос эхлэн эрэмбэлж, жагсаалт гаргана.
- 3.9.6. Сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлтэд үнэлгээний ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай гишүүн дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглүүлж гарын үсэг зурна.

3.9.7. Үнэлгээний ажлын хэсэг сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээ болон дүгнэлтийг Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.10. Үнэлгээний ажлын хэсэгтэй харилцах

3.10.1. Талууд сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлаар үнэлгээний ажлын хэсэгтэй төслийг нээхээс гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд зөвхөн бичгээр харилцана.

3.10.2. Төслийг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргах явцад оролцогчоос үнэлгээний ажлын хэсэгт нөлөө үзүүлэх аливаа оролдлого нь тухайн оролцогчоос ирүүлсэн төслөөс татгалзах үндэслэл болно.

3.11. Гомдол гаргах

3.11.1. Оролцогч нь сонгон шалгаруулалтын мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын **5 [тав]** хоногийн дотор бичгээр гомдол гаргаж болно.

3.12. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал

3.12.1. Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн үед Зохицуулах хороо зохих шийдвэрийг гаргаж, оролцогчдод албан бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ж. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

4.1. Гэрээ байгуулах эрх олгох

4.1.1. Үнэлгээний ажлын хэсэг нь баримт бичгийн 3.9.3-д заасны дагуу авбал зохих онооны 80 ба түүнээс дээш оноог авсан эхний оролцогчид гэрээ байгуулах эрх олгох талаарх дүгнэлтийг Зохицуулах хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

4.1.2. Зохицуулах хороо нь сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох, бусад оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдлийг албан бичгээр хүргүүлнэ.

4.2. Гэрээнд гарын үсэг зурах

4.2.1. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш **ажлын 10 [арав]** өдрийн дотор тусгай зөвшөөрлийн гэрээнд гарын үсэг зурж, гэрээг эцэслэн байгуулна.

4.2.2. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш **ажлын 10 [арав]** өдрийн дотор тусгай зөвшөөрлийн гэрээнд гарын үсэг зурж, гэрээг эцэслэн байгуулаагүй тохиолдолд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т заасны дагуу дараагийн хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдтэй гэрээ байгуулна.

4.3. Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

4.3.1. Оролцогч нь тухайн орон нутагт телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын дараах баримт бичигтэй танилцсан байна.

а. “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг татаж авах боломжтой.

<https://www.crc.gov.mn/storage/PDF/2021/2021-togtool02.pdf>

б. “Телевизийн хөтөлбөрт тавигдах нөхцөл, шаардлага”-ыг дараах линкээр орж татаж авах боломжтой.

<https://www.crc.gov.mn/storage/PDF/2021/2021-togtool01.pdf>

в. “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ыг дараах линкээр орж татаж авах боломжтой.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495453851&showType=1>

МАЯГТУУД

МАЯГТ №1

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

... он ... сар ... өдөр

Сонгон шалгаруулалтад оролцох тухай

Бид /сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр/, АрТВ-Орон нутаг-2025-2 дугаартай “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д оролцох хүсэлтэй байна.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга : _____

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

МАЯГТ №2
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

.... он сар өдөр

Мэдээлэлтэй танилцахыг зөвшөөрсөн тухай

Бид АрТВ-Орон нутаг-2025-2 дугаартай “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д оролцож байгаа тул үнэлгээний ажлын хэсэг манай компанитай холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн мэдээлэл болон Сангийн яамны цахим системийн мэдээлэлтэй танилцахыг зөвшөөрч байна.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр: _____

Зөвшөөрсөн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга :

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

МАЯГТ №3

**ТУХАЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ШААРДАГДАХ
АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Ажиллах боловсон хүчний жагсаалт (овог нэр)	Эзэмшсэн мэргэжил	Мэргэжлийн зэрэг, дэв	Ажлын дадлага туршлага	Тайлбар
А	Удирдлагын баг 1. 2.				
Б	Инженер техникийн ажилтан (ИТА) 1. 2.				
В	Мэргэжлийн ажилчид 1. 2. 3. 4.				

Тайлбар: Дээрх хүснэгтэд дараах зүйлүүдийг хавсаргаж, тусгана:

1. Тухайн ашиглалтыг явуулахад шаардлагатай орон тоо;
2. Төгссөн сургууль, цол хэргэм, мэргэжил дээшлүүлсэн байдал;
3. Ажлын дадлага туршлага гэсэн заалтад аль байгууллагад, ямар албан тушаалд, хэдий хугацаанд ажиллаж байсан талаар тодорхой дурдах.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Телевизийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага” MNS 5592-1:2012 стандартын 2.1-т **“Телевизийн студи - Төрөл бүрийн нэвтрүүлгийг бэлтгэх, бичих, боловсруулах, дамжуулах зэрэг телевизийн үйлдвэрлэл явуулах цогц техник төхөөрөмж бүхий, зайлшгүй шаардагдах нөхцлүүдийг хангасан, гадаад орчны нөлөөллөөс тусгаарлагдсан тусгайлсан объект”-ыг гэж, 3.1-т Телевизийн студийн байранд тавих шаардлагад Телевизийн студи нь дараах 3 хэсгээс (зона) бүрдэнэ:** 1. зургийн объект байрлах тайз, индэр, микрофон, камер, гэрэлтүүлгийн системээс бүрдсэн нэвтрүүлэг бэлтгэх, үйлдвэрлэл явуулах үндсэн өрөө, 2. дуу, дүрсийн мониторууд болон камеруудын удирдлага, тэдгээрийг ажиллуулах техникийн ажилтнууд болон найруулагчид байрлах удирдлага, хяналтын өрөө, 3. дуу дүрсийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байрлах техникийн өрөө” гэж, Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага MNS 5592-2 : 2016 стандартын 4.1-т **Телевизийн студид байвал зохих үндсэн тоног төхөөрөмжүүдийг** тус тус заасан байдаг.

Телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэвтрүүлэх, дамжуулахад шаардлагатай сүлжээ, студи, техник тоног төхөөрөмжийг тооцож, төлөвлөсөн байх шаардлагатай болно.

Иймд дор хүснэгтэд үзүүлсэн жагсаалтын дагуу тоног төхөөрөмжийн мэдээллийг бэлтгэхдээ дурдсан стандарт, нөхцөл шаардлагуудыг сайтар судлан үйл ажиллагаандаа уялдуулан дэлгэрэнгүй байдлаар гаргана уу.

Холбогдох стандарт, нөхцөл шаардлагыг дараах линкээс үзэж төлөвлөлтөө хийх боломжтой.

Телевизийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага MNS 5592-1:2012

<https://estandard.gov.mn/standard/reader/5454>

Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага MNS 5592-2:2016

<https://estandard.gov.mn/standard/reader/5456>

Телевизийн тоон архивын стандарт MNS 6304:2012

<https://estandard.gov.mn/standard/v/229>

№	Ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо ширхэг (хэмжээ)	Марк, загвар	Техникийн үндсэн үзүүлэлтүүд	Үйлдвэрлэсэн улс (vendor)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
А	Эфирийн удирдлага хяналтын өрөөнд (master control room) байрлах						

	үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт (дуу, дүрсийн хяналтын систем, микшерт пультууд болон камеруудын удирдлагын блок, <i>layout</i> серверүүд гэх мэт бусад)						

п	*****						
Б	Телевизийн студид ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт (микрофон, камерууд, суфлёр, студийн хяналтын дэлгэц, чанга яригч гэх мэт...)						

п	*****						
В	Бусад (Командын холбоо, ажлын компьютерууд, card, тог баригч, архивын систем гэх мэтбусад)						

Г	Гэрэлтүүлгийн систэм						

Д	Гал унтраах систем						

Е	Студийн тоо, хэмжээ (Ашиглах студийн тооноос хамаарч доош нь цувуулж бичнэ үү.)	Студийн талбай “S” м ²	Студийн өндөр “h” м	Студийн урт, “L”, м	Студийн өргөн, “B”, м	Нийт хэмжээ	Нийт үнэ

МАЯГТ №5

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН САНАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

Хэрэгжүүлэх ажлууд	Хугацаа /сар, өдөр/				
	сар	сар	сар	сар	сар
1.					
2.					

Тайлбар: Ажлын нэрийг нарийвчилсан задаргаатай гаргана.

МАЯГТ №6
ИЖ БҮРДЛИЙН МАЯГТ

Энэхүү баримт бичгийн холбогдох заалт	Төслийн иж бүрдэл	Шаардлага хангасан болон материалыг бүрдүүлсэн бол ✓ тэмдэглэгээ хийж, хуудасны дугаарыг тэмдэглэнэ	Хуудасны дугаар
2.7.1	Сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийн маягт №1-ийн дагуу албан бичиг		
2.7.2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн мэдээлэл болон Сангийн яамны цахим системийн мэдээлэлтэй танилцах зөвшөөрлийг маягт №2-ын дагуу албан бичиг		
2.7.3	Хуулийн этгээдийн хүчин төгөлдөр дүрмийн хуулбар		
2.7.5	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.5-д заасныг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын багийн бүрэлдэхүүний танилцуулгыг маягт №7-ын дагуу		
2.7.6	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2.1, 19.2.2, 19.2.3-д заасан эзэмшлийн талаарх мэдээллийг маягт №8-ын дагуу		
2.8.1	Телевизийн үйлчилгээ эрхлэх хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий батлагдсан 5 жилийн стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарь.		
2.9.1	Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хангах санхүүгийн чадавхийг нотлох баримтууд. Үүнд: 2.9.1 а, б, в		
2.9.2.а.	Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц бүрдүүлсэн тухай мэдээллийг ирүүлэхдээ маягт №3-ын дагуу		

2.9.2.6.	Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай инженер техник ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар		
2.9.3.а.	Үндсэн техник, тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн танилцуулга, жагсаалтыг маягт №4-ийн дагуу		
2.9.3.б	Техник, тоног төхөөрөмжийн үндсэн үүрэг, зориулалт, үзүүлэлтүүдийн жагсаалт, тоног төхөөрөмжийн холболтын схем, зураглал, тайлбар		
2.9.3.в.	Техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээ		
2.10.1	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т заасан Редакцын бодлого, дүрэм		
2.10.2	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10.8.4, 23 дугаар зүйлийн 23.5-д заасан хөтөлбөрт тавигдах шаардлагыг хэрхэн хангаж ажиллах талаарх төлөвлөлт, бүтээл, нэвтрүүлгийн жагсаалт, танилцуулга, 30 хоногийн хөтөлбөр		
2.11.1	Төслийг хэрэгжүүлнээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд үзүүлэх нөлөө, үнэ тариф, хөтөлбөр, агуулга, чанараар өрсөлдөх зэргийг судалсан судалгаа		

МАЯГТ №7

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

(ТУЗ-ийн гишүүд, компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хяналтын зөвлөлийн гишүүд, Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал, Дэд захирал гм, Ерөнхий нягтлан, Удирдлагын баг, Менежер болон бусад эрх бүхий албан тушаалтан, бусад удирдлагын багийн гишүүн)

д/д	Албан тушаал	Эцэг /эх/- ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Иргэний харьяалал, Улс	Байнга оршин суугаа газрын хаяг
	1	2	3	4	5
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
...					

МАЯГТ №8

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

1.	Өргөдөл гаргасан огноо:	
2.	Хуулийн этгээдийн регистрийн дугаар:	
3.	Хуулийн этгээдийн нэр:	
4.	Үүсэн байгуулагдсан огноо:	
5.	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо:	

6. Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/- ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр*/	Регистрийн дугаар	Харьяа- лал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаа нд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						
...						

**Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.1 хүснэгтийн дагуу мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./*

6.1 Хуулийн этгээд (1, 2, ...n)-ийн нэр:

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/- ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр*/	Регистрийн дугаар	Харьяа- лал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаа нд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						

...						
<i>*Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.2 хүснэгтийн дагуу мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./</i>						
6.2 Хуулийн этгээд (1, 2, ...n)-ийн нэр:						
Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр*/	Регистрийн дугаар	Харьяалал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаанд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						
...						
<i>* Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.2 хүснэгтийн дагуу НЭМЖ мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./</i>						
7. Эрх бүхий албан тушаалтны жагсаалт: [Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1: Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. 84.2: Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна.]						
Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр			Иргэний харьяалал		Албан тушаал	
1.						
2.						
3.						
8. Хуулийн этгээд, түүний хувьцаа эзэмшигч, өмчлөгчийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад хуулийн этгээдэд* эзэмшиж байгаа хувьцаа, хувь хэмжээ: <i>*/хэрэв нөхөрлөл бол 8.1 хүснэгтийг мэдүүлнэ./</i>						
Хуулийн этгээдийн нэр, хэлбэр (ХХК, ХК, ...)	Хуулийн этгээдийн регистрийн дугаар, үүсэн байгуулагдсан огноо	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо	Эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар)	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Хувьцаанд эзлэх хувь
				Энгийн	Давуу эрхийн	
1	2	3	4	5	6	7
1.						

2.					
3.					
...					
...					
8.1 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нөхөрлөлд оруулсан эд хөрөнгийн хэмжээ:					
Нөхөрлөлийн нэр, хэлбэр (Бүх гишүүд нь эсвэл зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай, эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай)	Хуулийн этгээдийн регистрийн дугаар, үүсэн байгуулагдсан огноо	Нийт гишүүний тоо	Эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар)	Үүсгэн байгуулах гэрээнд заасан нөхөрлөлийн нийт эд хөрөнгө (төгрөг)	Үүнээс мэдээлэл гаргагчийн оруулсан эд хөрөнгө (төгрөг)
1	2	3	4	5	6
1.					
2.					
3.					
9. Хуулийн этгээдийн эзэмшиж буй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нэр, төрөл, тоо:					
Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн төрөл		Олгогдсон огноо	Шийдвэрийн дугаар		
1.					
2.					
3.					
...					
10. Хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар):					
11. Нэмэлтээр өгөх тайлбар, мэдээлэл байвал ирүүлэх:					

Өргөдөл гаргаж байгаа эрх бүхий этгээд нь эзэмшлийн талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж ирүүлэх үүрэгтэй бөгөөд мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

/Хуулийн этгээдийн
тэмдэг/

/Гарын үсэг/

МАЯГТ №9

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛИЙН
МАЯГТ**

Сонгон шалгаруулалтын нэр:	
Сонгон шалгаруулалтын дугаар:	

Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн нэр:	
Сонгон шалгаруулалтын төсөл ирүүлсэн огноо, хугацаа:	
Сонгон шалгаруулалтын төсөл хүлээлгэн өгсөн хүний нэр, албан тушаал:	
Холбоо барих утас:	
Баталгаажуулалт: /гарын үсэг /	

Сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авсан хүний нэр, албан тушаал:	
Хүлээн авсан огноо, хугацаа:	

МАЯГТ №10

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН НЭЭЛТИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН МАЯГТ

Сонгон шалгаруулалтын нэр:	
Сонгон шалгаруулалтын дугаар:	

Сонгон шалгаруулалтыг хүлээн авах эцсийн хугацаанд буюу 2025 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө ирүүлсэн сонгон шалгаруулалтын материалуудыг мөн өдрийн 11 цаг 30 минутад нээж, дор дурдсан мэдээллийг зарлаж тэмдэглэв.

№	Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр	Төслийн бичиглэл	Төслийн битүүмжлэл	Нээлтэд оролцсон хүний нэр, албан тушаал	Гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
...					

МАЯГТ №11

НУУЦ ХАДГАЛАХ БАТАЛГААНЫ МАЯГТ

(Энэхүү баталгааг АрТВ-Орон нутаг-2025-2 дугаартай “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг зохион байгуулах үнэлгээний ажлын хэсгийн гишүүн бүр гаргана.)

Нууц хадгалах баталгаа гаргасан огноо	
Нууц хадгалах баталгаа гаргагчийн овог, нэр	
Сонгон шалгаруулалтын дугаар	
Үнэлгээний ажлын хэсэгт томилсон шийдвэрийн огноо, дугаар	

Ажлын хэсгийн дарга/гишүүн/нарийн бичиг _____ овогтой _____ би сонгон шалгаруулалтад оролцогчдийн төсөлтэй танилцах болсонтой холбогдуулан энэхүү нууцлалын баталгааг гаргаж байна.

Миний бие “Байгууллагын нууцын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлд заасан дагуу сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагын нууц мэдээлэлтэй танилцах эрх бүхий этгээдээр томилогдсоноо ухамсарлан, албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахгүй байх үүрэгтэй болохоо үүгээр баталгаажуулж байна.

Энэхүү нууц мэдээлэл гэдэгт Байгууллагын нууцын тухай хуулийн 7.3-д заасанчлан “хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууц мэдээлэл” хамаарахгүй болно.

Нууцлалын баталгаа гаргасан:

Үнэлгээний ажлын хэсгийн гишүүн: _____ /..... /

МАЯГТ №12

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР

Нэг. Нийтийн албан тушаалтан

Эцэг/эхийн нэр.....	Нэр:.....	Регистрийн дугаар.....
Ажиллаж буй байгууллага.....		Албан тушаал:.....
Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан байгууллагын нэр:.....		
Мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэл:.....		

Хоёр. Мэдэгдэл, тайлбарын аль нь болохыг сонгон $\checkmark$ тэмдэглэгээг хийнэ үү.

- ☐ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй
(Зөвхөн гурав дахь хэсгийн мэдэгдлийг гаргах)
- ☐ Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн
(Зөвхөн дөрөв дэх хэсгийн тайлбарыг гаргах)

Гурав. Мэдэгдэл

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд өөрийн хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх буюу албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Мэдэгдэл тодорхой бичих:

Дөрөв. Тайлбар

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” буюу өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүнтэй

холбоотой зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу тайлбарлаж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Тайлбар тодорхой бичих:

Тав. Нийтийн албан тушаалтны баталгаажуулалт:

_____ би нийтийн албан тушаалтны үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдэл/тайлбарыг (аль нь болохыг доогуур нь зурах) үнэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

..... (.....)

(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал) (огноо)

Зургаа. Шийдвэрлэсэн байдал

Шийдвэр гаргах удирдах албан тушаалтан /нэр/ _____ би нийтийн албан тушаалтан /нэр/ _____ -ийн/ын/ гаргасан мэдэгдэл, тайлбарт үндэслэн тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхийг зөвшөөрсөн эсэх:

☐

Тийм

☐

Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ үү.

☐

тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн чиг үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй;

☐

дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;

☐

тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

Шийдвэр гаргасан удирдах албан тушаалтны баталгаажуулалт:

..... /...../

(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал) (огноо)

ЭБАТ-аас бөглөх хэсэг:

_____ (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) _____ (Гарын үсэг)

_____ (Мэдэгдэл/тайлбарыг бүртгэсэн огноо)